

БАТЛАВ:
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА *Ш. Энхжаргал* Т.ЭНХЖАРГАЛ



ЖАРГАЛАНТ СУМЫН ЗДТГ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

Улаантолгой багийн гудамж хооронд сайжруулсан
зам хэсэгчилэн тавих /13-14/, /14-15/

Төслийн дугаар:

ОРАЖСЗДТГ/202001004

Орхон аймаг
2020 он

Нэг. ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **Улаантолгой багийн гудамж хооронд сайжруулсан зам хэсэгчилэн тавих /13-14/, /14-15/**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОРАЖСЗДТГ/202001004**

Огноо: **2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр**

Жаргалант сумын ЗДТГазар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Улаантолгой багийн гудамж хооронд сайжруулсан зам хэсэгчилэн тавих /13-14/, /14-15/ ажлыг гүйцэтгэх тухай ЦАХИМ үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэхүү харьцуулалтын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийг илгээхийн өмнө 30000 /гучин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 09.00 минут-аас өмнө www.tender.gov.mn** сайтаар орж өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч **www.tender.gov.mn** сайтаар дамжуулан цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 04 дүгээр сарын 02-ны 09 цаг 30 минутад Жаргалант сумын ЗДТГ-ын Хурлын зааланд** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ
Нутгийн удирдлагын ордон
Утас:70397202**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ: Үүнд:
 1. Үнийн санал
 2. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь
 3. Улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувиас скайнердаж ирүүлэх
 4. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрээний хамт эх хувиас скайнердаж ирүүлэх
 5. Тендерт оролцогчийг төлөөлөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг эх хувиас скайнердаж ирүүлнэ. Итгэмжлэгчийн цахим иргэний үнэмлэх эх хувиас скайнердаж ирүүлэх
 6. Харьяа татварын байгууллагын тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх-/тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байх/.Мөн тендер нээсэн өдрөөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс өр төлбөрийн тодорхойлолтийг татаж шалгах бөгөөд өр, төлбөртэй байвал шууд татгалзана.
 7. Харилцагч банкны тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх /өр төлбөр болон зээлийн талаарх мэдээллийг харилцагч банк бүрээр/
 8. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх /даатгуулагчийн тоо, өр төлбөргүй талаарх/
 9. Шүүхийн магадлагаа эх хувиас скайнердаж ирүүлэх
 10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын лавлагаа эх

хувиас скайнердаж ирүүлэх.

11. Тендерт оролцогч нь Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дугаар тогтоолын хавсралтад тусгагдсан дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан бараа, барилгын материалуудыг дотоодын үйлдвэрээс авч ашиглах бөгөөд түүнийг нотлох бичиг баримт заавал ирүүлнэ.

12. Сүүлийн 2 жилийн ажлын гүйцэтгэлийн жагсаалт, үнийн дүн, гэрээ, хүлээлгэн өгсөн актыг эх хувиас скайнердаж ирүүлэх

13. Баталгаажсан, аудитлагдсан 2018, 2019 оны санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт эх хувиас скайнердаж ирүүлэх

14. Ннженер, техникийн ажилтнуудын судалгаа диплом, мэргэжлийн үнэмлэх, цахим үнэмлэхний хуулбарыг эх хувиас скайнердаж ирүүлэх.

15. Ажлын тоо хэмжээ, ажлын зургийн дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажсан байна. Жич: Магадлашгүй ажлын зардал, Захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал зураг төсөв, норм нормативийн сангийн зардлыг төсөвт зохих зааврын дагуу, мөн татвар, хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлэх ба зураг төсвийн үнийг хяналтын төсөвт тусгаснаар тооцож ирүүлнэ.

16. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиас скайнердаж ирүүлэх

17. Захиалагч татвар, нийгмийн даатгал, харилцагч банк болон бусад холбогдох байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй гэсэн тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх.

18. Тендерт оролцогч нь тендерийн жишиг маягтуудаас зохих маягтыг ашиглан тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтын үг, өгүүлбэрт утга агуулгыг нь өөрчилсөн буюу орхигдуулсан аливаа өөрчлөлт хийхийг зөвшөөрөхгүй. Маягт дахь бүх хоосон зайд шаардсан мэдээллийг нөхөж бичих бөгөөд дутуу ирүүлсэн, өөрчилж ирүүлсэн магтыг хүчингүйд тооцно. Мөн тендерт ирүүлсэн тодорхойлолтууд нь тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.

4. Тендерийн үнэ

- 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
- 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх

нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

6. Алдааг залруулах

6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. /Техникийн

тодорхойлолтыг хангаж буй талаар нотлох баримт ирүүлнэ, Тендер зарлагдсан өдрөөс хойшхи хугацаанд тодорхойлолтуудыг авсан байх шаардлагатай/

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**9. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

9.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчийн бэлтгэн ирүүлсэн материал нь ТӨӨЗ-ны 3.1-т заасан иж бүрдлээс бүрдсэн байна. 2. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Хайрган хучилттай зам барих тусгай зөвшөөрөлтэй байх ба гэрээний хамт эх хувиас скайнердаж ирүүлнэ. 3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Индүү - Экскаватор - Авто грейдер 4. Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ
ТӨӨЗ 13.1	<p>Жич:Тендерт оролцогч нь ТББ-тэй бүрэн танилцсан байх шаардлагатай бөгөөд тендерийг цахим хэлбэрээр илгээхдээ бэлтгэсэн материалын товъёогын дагуу бүх файлыг /PDF/ файлаар ирүүлнэ. Тендерийн баримт бичгийг дутуу, товъёогийн дагуу бус болон PDF-ээс өөр файлаар ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр. Цаг: 10 цаг 00 минут</p> <p>Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар ААН-ийн хувийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим (PDF) файл хэлбэрээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна.</p> <p>Мөн ТББ-т шаардсан баримт бичгүүдийн Эх хувиас скайнердаж ирүүлснийг ЭХ ХУВЬ гэж тооцох бөгөөд нотариатаар баталгаажуулсан баримт бичгийг эх хувьд тооцохгүй. Эх хувийг ямар нэгэн хэлбэрээр хуурамчаар үйлдсэн тохиолдолд тендерээс шууд татгалзаж, эрх бүхий байгууллагад хандаж “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хамруулна</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Жаргалант сумын ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: ЗДТГ-ын 1-р давхарт, Санхүү алба Аймаг, хот: Орхон аймаг Жаргалант сум Улс: Монгол Улс</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр. Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	Тендерт оролцогчийн дараах бичиг баримтуудыг нээлттэй ил тод болгоно.

	<ul style="list-style-type: none"><input type="checkbox"/> Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ<input type="checkbox"/> Шүүхийн тодорхойлолт<input type="checkbox"/> Мэдэгдэл, албан бичгүүд<input type="checkbox"/> Ажил гүйцэтгэх хуваарь<input type="checkbox"/> Техник тоног төхөөрөмжийн чадавхийн мэдээлэл<input type="checkbox"/> Ажиллах хүчний чадавхийн мэдээлэл <p>Дээрх бичиг баримтуудыг тендерт оролцогч нарт нээлтэй үзүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх.</p>
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Төсвийн задаргаа	Бүгд төсөвт өртөг
1	Ажиллах хүчний зардал	
2	Материал	
3	Тээвэр	
4	Машин ашиглалт	
5	Нэмэгдэл зардал	
6	Ашиг	
7	НӨАТ	
8	Нормчлолын сан	
9	Захиалагчийн албаны зардал	125121
10	Зураг төсөл	256565
11	Зохиогчийн хяналтын зардал	158585
12	Магадлашгүй ажлын зардал	158158
13	Бусад нэмэгдэл зардал	
	НИЙТ ДҮН	

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ – /Хяналтын төсвөөс харна уу. /

а/ Ажлын тоо хэмжээг үнэлэх санамж:

1. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ үнэлэгдэх ажлын тоо хэмжээний жагсаалт болон тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт зэргийг бодит байдалтай холбож нягтлан үзэхийг анхааруулж байна.
2. Гэрээнд тусгайлан заагаагүй нөхцөлд тендерт ирүүлсэн үнийн саналд ажлын тоо хэмжээнд тохирсон үнэд барилгын ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, ажиллах хүчний хөлс, материал, түүний элэгдэл засвар, нийгмийн ба эрүүл мэнд, үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн зардлууд, ашиг бүх төрлийн татвар хураамж, /НӨТ, гаалийн татвар г.м/ банкны үйлчилгээний шимтгэл, үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалттай бүх зардлууд /сорилт, туршилт, баталгаажуулалт, гадаад ажилтнуудын ирэх, буцах болон тэдгээрийн Монгол улсад ажиллуулахтай холбогдсон зардал, ажилчдын байрлах байр, ажилчдыг зөөх унаа г.м/ мөн нэмэгдэл дайвар ба захиалагчийн техник хяналтын зардал болон гэрээний үүрэгт хамруулах ёстой бусад үүрэг хариуцлагыг тооцож шингээсэн байна.
3. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ шинэчлэгдсэн программын дагуу үнэлж, үнэлгээнд техник хяналт, магадлашгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсвийн үнэ, нормчлолын санг тооцож оруулна. Ажлын тоо

хэмжээг тооцсон төсвийн дүн нь тендерт ирүүлж буй үнийн саналтай ижил байна. Хэрэв хөнгөлөлт үзүүлсэн бол ямар зардлаас гэдгээ тендерийн маягтанд бичиж ирүүлнэ.

4. Ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг үнэлэхдээ ажил гүйцэтгэх технологийн дагуу ажил, ажилбаруудаар задалж нэгжийн норм үнэлгээгээр үнэлэхийг анхааруулж байна. Гэхдээ нэгжийн норм үнэлгээ дотроо тусгагдсан ажилбаруудыг дахин давтан үнэлсэн байж болохгүй.
5. Талбайгаас гарсан хог хаягдалыг Хот тохижуулах газрын зөвшөөрөгдсөн хогийн цэгт тээвэрлэж зайлуулахаар зардлыг тооцож ирүүлнэ.
6. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан, санал болгосон хугацаанд, ажлыг чанартай хийж, дуусган хүлээлгэж өгөх баталгааг бичгээр гаргаж тендерт ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. /Баталгааг хэрэгжүүлээгүй тохиолдолд гэрээний үүргийн биелэлтийг хангаагүйд тооцно./
7. Тендерт оролцогч нь захиалагчийн тавьсан шаардлага, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээний дагуу ажлыг гүйцэтгэх тухай албан мэдэгдлийг эх хувиар ирүүлнэ.

Дээрхи техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болохоос гадна шалгарсан тохиолдолд захиалагчийн төлөөлөгч эрхийнхээ дагуу ажлыг зогсоож зөрчлийг арилгуулсны үндсэн дээр ажлыг үргэлжлүүлнэ.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж- Улаантолгой багийн гудамж хооронд сайжруулсан зам хэсэгчилэн тавих /13-14/, /14-15/

Шифр: ХББЗА-207/17

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Ажил гүйцэтгэх график ирүүлэх

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА *Г. Энхжаргал* Г.ЭНХЖАРГАЛ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

.Авто замын ажил, холбогдох инженерийн шугам сүлжээний ажлын явцад гүйцэтгэгч байгууллага ажлыг холбогдох норм дүрэм, стандарт, техникийн шаардлагад заасны дагуу чанарын гологдолгүй хийх бөгөөд ажлын график төлөвлөгөө, технологийн аргачлалаа боловсруулж ирүүлнэ.

Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний хугацаанд зайлшгүй байрлуулах шаардлагатай.

1.Замын ажилд тавигдах шаардлага

а.Зам талбайн ажлыг гүйцэтгэхдээ ажлын зураг болон бусад холбогдох баримт бичгийн дагуу хийж гүйцэтгэнэ.

2.Замын хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглол тохижилт

а.Зам барилгын ажлын үед шаардлагатай нэмэлт гарцуудыг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн нэмж гаргаж болох ба аливаа гарцыг гаргахдаа замын ус зайлуулалтыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдал ба замын нэвтрүүлэх чадвар, тооцоот хурд хангалтыг бууруулахгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.Зам барилгын ажилд тавигдах техникийн шаардлага

Тус замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ ажлын зураг тус бүрийн техникийн шаардлага болон "Эрдэнэт хот, хот орчмын замын барилга, шинэчлэлт, их засварын ажлын техникийн шаардлага -д нийцүүлэн гүйцэтгэнэ

БНБД 32.02.00 авто зам барих дүрмийн дагуу ажиллахдаа доорхи норм шаардлагуудыг хатуу барин ажиллах. Үүнд

а.БНБД 32.01.04 авто зам төлөвлөлтийн зорчих хэсгийн хучилтыг 21 бүлгийн 49-р зүйл, далангийн ажлыг 2-р бүлгийн 38-р зүйлийн дагуу, ногоон байгууламж,

тусгаарлах зурвасыг 5-р бүлгийн дагуу, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлтийг 3-р бүлгийн дагуу, газар доорхи инженерийн байгуулалтын төлөвлөлтийг 7-р бүлгийн дагуу, гудамж замын гадаргын ус зайлуулах байгууламжийг 8-р бүлгийн дагуу, хотын гудамж талбайн гэрэлтүүлгийг 9-р бүлгийн дагуу хийж гүйцэтгэнэ.

б.Одоо байгаа борооны ус зайлуулах хоолой болон худгийг ашиглагч байгууллагад гүйцэтгэгч актаар хүлээлгэн өгч ажил дууссаны дараа гүйцэтгэгч байгууллага ашиглагч байгууллагад мөн актаар хүлээлцэх, шинээр барих хоолой БнБД 33.06.09 -р гүйцэтгэнэ.

в.Зам талбайн ажлыг гүйцэтгэхдээ ажлын зураг болон бусад холбогдох баримт бичгийн дагуу хийж гүйцэтгэнэ. Ингэхдээ итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэсэн чанартай шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.

4.Тусгай шаардлага

Ажлын батлагдсан зураг төсөл болон холбогдох стандарт, норм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Ажлын явцад гарсан хог хаягдлыг Хот тохижуулах газартай гэрээ байгуулан төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.

Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хуульд заасны дагуу мөрдөж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж, ажлын төсөвт багтааж, зарцуулах

Оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хашаа хамгаалалтыг хийж оршин суугчдын зорчих хэсгийг гаргаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнууд хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна.

Гүйцэтгэгч нь ашиглагч, хангагч байгууллагуудтай уялдаатай ажиллана.

Ажлыг гүйцэтгэх үед нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, инженерийн шугам, зогсоол, явган зам, холбоо, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангах, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Байгалийн гэнэтийн

гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.

Гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд тендерийн саналын үнэлсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэлгээ болон үнэ нь гэрэлтүүлгийн ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, хүн хүч хяналт, материал, ашиг татвар хураамж болон гэрээний хүрээнд хүлээх ёстой үүрэг хариуцлагыг хамруулсан байна.

Ажлын тоо хэмжээнд тодорхойлсон магадлашгүй ажлын зардлыг зарцуулахад захиалагчийн зөвшөөрөл баталгааг авна

Тендерийн нийт үнэд НӨТ, нормчлолын сангийн шимтгэл, дараах зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг төсөвт тусгаж өгнө

Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдэллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний хугацаанд зайлшгүй байрлуулах шаардлагатай. /Ажлын гүйцэтгэлийн явцад тулган баталгаажуулна./

Ажлыг гүйцэтгэх технологийн аргачлал, календарчилсан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь чанарын гологдолгүй ажиллахад анхаарах хэрэгтэй

Долоо.ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Т.ЭНХЖАРГАЛ ТАНАА**

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]*, *[гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр**
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал**
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа**
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх**
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр**
 - 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол**
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү

- илрүүлэх** шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
- Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
- Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй,

түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг
цуцалсан
үед хийх
төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлэ
эс
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын

хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Улаантолгой багийн гудамж хооронд сайжруулсан зам хэсэгчилэн тавих /13-14/, /14-15/ ОРАЖСЗДТГ/202001004
ГЕН 2.1	Ажил нь Улаантолгой багийн гудамж хооронд сайжруулсан зам хэсэгчилэн тавих /13-14/, /14-15/ ажлаас бүрдэнэ.
ГЕН 3.1	Төслийн менежер нь Гэрээний хэлэлцээр хийх үед тодорхойлно.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр Гэрээ батлагдсан өдрөөс эхлэн ажил эхлэх өдөр тооцогдоно. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр Уг ажлыг хуанлийн 30 хоногт хийж гүйцэтгэнэ.
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [5] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа: МУ-ын барилгын тухай хуулийн 14.3 Барилга байгууламжийг ашиглалтанд зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. 14.6 Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсоноос хойш барилга байгууламжийн гадна дотор засал, бүх төрлийн материал, үндсэн, үндсэн хийц, бүтээц, цэвэр бохир ус ,уур, хий, дулаан цахилгаан харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3 жилээс доошгүй байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0.05 хувь] байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [5 хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [3 хоногийн]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [5 хоногийн]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [тухайн материалыг бэлтгэхэд гарах зардлын хэмжээтэй тэнцүү] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [00 хувь]-иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж

суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ЭРДЭНЭТ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН А/БА
/ЭРДЭНЭТ ХОТ, УРТ БУУЛГ БАГ, НҮГТНИЙ ҮЙНЭРДЛАГЫН ОРЛОН /

ЕГ шифр : - ХЭА 179Д/2018

**ОРХОН АЙМАГ, ЖАРГАЛАНТ СУМ, УЛАН ТОЛГОЙ БАГ,
13-14, 14-15-Р ГУДАМЖНЫ ДУНД САЙЖРУУЛСАН ШОРООН ЗАМ**

(ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ)

ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭСЭГ - ЕТ

Балдсруулсан

Гүйцэтгэгч	Ардан тугшар
Хөхон мандуучи- ынба	Дарса Ижнээр

Нэр	М. Түвшинбаяр
Ш. Олзонцалзэг	

Гүйцэтгэгч
М. Түвшинбаяр
Ш. Олзонцалзэг



Эрдэнэт хам
2018 он

Зургийн жагсаалт

Д/д	Нэр	Хуудас
1	Зургийн жагсаалт, Талбар бичиг	ЕТ-1
2	Шороон замын байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	ЕТ-2
3	13-14, 14-15-р сүдэвчийн шороон замын байгуулалт	ЕТ-3
4	Фотو зураг	ЕТ-4
5	Фото зураг	ЕТ-5

Ерөнхий хязга

Орчин аймаг, Жаргалант сум, Ундан ноорог багийн шороон замын заагдрын ажлын зургийг Холын захиргаачийн албанд байгуулжээ. Энэхүү зураг төслийн хэмжээнд Ундан ноорог багийн Заасаг даргаар иргэн хүсэлтэй дагдү Холын захиргаачийн албаны мэргэжилтнүүд агаар баар нь үзэж шалгалтын үндсэн дээр хийсэн байна.

Эрдэмт хэлмэг цаг уурын үндсэн үзүүлэлтүүд

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжээ Нэгж	Т ооно цмд	
1	Агаарын жилийн бундаж температур	Нэгж	0.5	
2	Агаарын үнэмлэхүү хангалт их температур /1984.01.14./	°C	40.1	
3	Үнэмлэхүү хэдий VII сарын бундаж	°C	27.7	
4	Агаарын үнэмлэхүү хангалт бага температур /1995.01.12./	°C	-40.8	
5	I сарын үнэмлэхүү бага бундаж температур	°C	-30.6	
6	Агаарын чийгшил, хур тунадсны хэмжээ	Чийгшил	Халуун сар	56.0
		Хур тунадсны хэмжээ	Хүйтэн сар	63.0
6	Хур тунадсны хэмжээ	Хур тунадс	Жуул	352.5
		Хангалт	Дундаж үе	336.6
	Хангалт хангалт их температур	°C	65.3	

Талбар бичиг

Зургийн заагаар баарн зураг хийж хийгээд зогсон гом нь ширт усны болон зүйн хур болонны үед урсгалтай болж зарим үед цээхэн хэмжээний могоод Угч шалгарын харагддаг. Ивэн гүн торч болонхгүй байдаг.

Ивэн үг зарим эвдн тохиолдолд ширдэгээр хөрсөд 6-200мм-ийн зувагналда шурж шийдүүдэн зөвшөөрөгчдэй холбоотой төлөвөөр өгч өссөнд Тохиромжгүй хөрсөд шурж шийдүүдэн дарва улсгалыг эвддэг Чийг үрвэж шийдн байгуулдаг. 6-200мм, чийгүүд сууриад нэвтрүүлдэг дарва зонд тохиолдолд хөрсөд мөн 6-200мм-ийн зувагналда нэгж хүйсн.

Ажил эхлэхийн өмнө холбоодог байгууллага болон нэрлэгчлэнгүүдэд төлөвлөгөө Алмо замын барилдаг байгуулалтын 6х6д-ийн дагдү бүлэглэнэ.




МОНГОЛ АЙМАГ, ЖАРГАЛАНТ СУМ УНДАН НОРОГ БАЙ

13-14, 14-15-р сүдэвчийн шороон замын захиргаа

ТАЛБАР БИЧИГ

Инженер	Ш. Оронцолз	Э.Т. Шаар	Насанда	Билэн
Гүйцэтгэл	Ш. Оронцолз	МЭН-1331/208	Зургийн зурагч	Хуудас
Шалгалт	Б. Агаарханад	Т.Г. Ивэн	Хуудас	5

Шороон замын байгуулалттай ерөнхий төлөвлөгөө М:1:5000



№ 1
 Ерөнхий Төлөвлөгөө
 Бадаршдын СХДН
 Тухайн 0:00
 М:1:50

АЖИЛ ТОО ХЭВЭЭ /Д.%-р өрбөж /

А/Я	Ажлын нэр	Кажил нэгж	Төгс хэвээ
1	Замын шал сүлжээ	м	0.505
2	Тооцогжирч ямарилалт үзэл үнэм	м ²	7115
3	Бүтээлийн үндэн тэмдэг байгуулалт	м ³	595.9
4	Иргэдийн сургууль байгуулалт ба тэдгээрийн Зөвхөн өргөжүүлэх явдал нэмж хучилалт байгуулалт ба тэдгээрийн	м ²	501.0

АЖИЛ ТОО ХЭВЭЭ /Д.%-р өрбөж /

А/Я	Ажлын нэр	Кажил нэгж	Төгс хэвээ
1	Замын шал сүлжээ	м	0.525
2	Тооцогжирч ямарилалт үзэл үнэм	м ²	536.0
3	Бүтээлийн үндэн тэмдэг байгуулалт	м ³	524.0
4	Иргэдийн сургууль байгуулалт ба тэдгээрийн Зөвхөн өргөжүүлэх явдал нэмж хучилалт байгуулалт ба тэдгээрийн	м ²	426.0

ХАМГАЙН ГЭТЭЙН 1:1



Төрийн зах зээлийн
 байгууллагад захиарай
 байгууллагад захиарай
 байгууллагад захиарай
 байгууллагад захиарай



Урьдчилсан гэрээний үндсэн дээр
 1) №. 14. 0-0 ТЭМДЭГЭЙН ДЭВЭ СЭЙНЭГЭЙН ШОРООН АЖ

Урьдчилсан гэрээний үндсэн дээр
 2) №. 14. 0-0 ТЭМДЭГЭЙН ДЭВЭ СЭЙНЭГЭЙН ШОРООН АЖ

Урьдчилсан гэрээний үндсэн дээр
 3) №. 14. 0-0 ТЭМДЭГЭЙН ДЭВЭ СЭЙНЭГЭЙН ШОРООН АЖ

Урьдчилсан гэрээний үндсэн дээр
 4) №. 14. 0-0 ТЭМДЭГЭЙН ДЭВЭ СЭЙНЭГЭЙН ШОРООН АЖ

Урьдчилсан гэрээний үндсэн дээр
 5) №. 14. 0-0 ТЭМДЭГЭЙН ДЭВЭ СЭЙНЭГЭЙН ШОРООН АЖ






ҚАЗАҚСТАН РЕСПУБЛИКАСЫНЫҢ
ТАБИИИ РЕСУРСАЛАР ЖӘНЕ ЭКОЛОГИЯ МИНИСТРЛІГІ

БҰҒАЛАР АМАЛ - ЖАСТАЛАДІ СІМ ТАКАТ ТУРҒАН БАҒ.

19-№ 1А-Қ/19 ПІЛІМДІК АҚПАРАТ СЫЗДЫ ҚАТЫСТЫРА АЛМАЙДЫ.

Қазақстан Республикасының Табиғи Ресурс және Экология Министрлігі

Әкімі	Ш. Диналиев	Е. Т. Шырғалиев	Қосымша	Қазан
Қарағанды	Ш. Диналиев	Х.А. Қыдыр	2019/2018	20/01/2018
Қарағанды	Ш. Диналиев	Т. Г. Шырғалиев	Қарағанды	Қарағанды
Қарағанды	Ш. Диналиев	Т. Г. Шырғалиев	Қарағанды	Қарағанды



БОСОН АЙДАГ ЖАНГАЛДИГ ГЭН ШИДЭГ ТӨГӨД 1:40
 13-14, 14, 15-17 ТУСГААРЫН ГЭНД САНХҮҮРЭГЧИЛЭЭН БОЛОН ЭМН

Төрөл	Тусгаар	Төрөл	Тусгаар
Нийслэл	Ш. Оронцолон	Урьдчилсан	Ш. Оронцолон
Урьдчилсан	Ш. Оронцолон	Т.Т. Шидэг	Эргэлт бусад: Хууль
Шийдсэн	Б. Аюулхуянд	Эргэлт бусад: Хууль	ЭГ-5
ТАКРЫН ЭМН		Мөсөл	Онц
 Э.Г. Шидэг Х.М. 093/708		Эргэлт бусад: Хууль	Онц
 Т.Т. Шидэг		Эргэлт бусад: Хууль	Онц
 Э.Г. Шидэг Х.М. 093/708		Эргэлт бусад: Хууль	Онц
 Т.Т. Шидэг		Эргэлт бусад: Хууль	Онц

Батлав: Засаг дарга
Б.Зоригтбаяр



Зөвшөөрсөн: Засаг даргын орлогч
Хотын захиралгийн албаны дарга

С.Батжаргал
М.Түмэнжаргал



**Орхон аймаг. Жаргалант сум. Удаан толгой баг.
сайжруулсан шороон замын засварын төсөв.**

/13- 14-р гудамжны дунд, 14-15-р гудамжны дунд/

Төсвийн № 179д /2018
Төсөвт өртөг – 43 381 817 төгрөг



Төсөв зохиосон :
Д.Нарантуяа

Эрдэнэт хот. 2018 он

13-р гудамжнаас 14 -р гудамжны дунд , 14-р гудамжнаас 15-р гудамжны дундах сайжруулсан шороон замын засварын төсөвт өртөгийн товчоо

№	Зардлын нэр	Төсөвт өртөг /төгрөг/
1	Ажилчдын цалин	1152328
2	Тээвэр, машин ашиглалтын цалин	1918451
3	Ажилчдын нэмэгдэл цалин	463688
4	Талбайн ИТА-гийн цалин	463356
5	Алслалын нэмэгдэл цалин	0
6	Нийт цалин	3997823
7	Нийгмийн даатгалын шимтгэл	519717
8	Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт	12488380
9	Материал	5323706
10	Тээвэр	8495254
11	Багаж хэрэгсэлийн элэгдэл	49512
12	Ажлын хувцасны элэгдэл	38855
13	Түр барилгын элэгдэл	0
14	Нүүлгэн шилжүүлэх зардал	858807
15	Шууд зардлын дүн	31772054
16	Удирдлагын зардал 63.5%	2538618
17	Ашиг 71.8%	2870437
18	Ажиллагсадын даатгал	31983
19	Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал	0
20	Барилга, угсралтын ажлын даатгал	127088
21	Ажиллагсдын хээрийн нэмэгдэл	0
22	Дүн	37340179
23	Захиалагчийн хяналтын зардал 2%	746804
24	Магадлашгүй ажил	746804
25	НӨАТ 10%	3734018
26	Норм, нормативын сан 0.18%	67212
27	Техник ашиглалтын түвшин тогтоох зардал	0
28	Дүн	42635014
29	Зураг төсвийн үнэ	746804
30	Дүн	43381817

ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

УЛААН ТОЛГОЙ БАГИЙН 13,14 -Р ГУДАМЖНЫ ДУНД / 505М X 5М/

Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэрэг/Тариф	Нэгж хүн-цаг	Нийт хүн-цаг	Бүгд цалин	Нэмэгдэл цалин	Алслагтын нэмэгдэл	Нийт цалин
25-02-01	Замын чигийг сэргээх	1км	0.505	3.6 / 2914	38.82	19.6	57129	8626	0	65755
25-04-69	Тохиромжгүй материалыг ухаж ачих б-300мм	1м3	757.5	0.0 / 0	0	0	0	0	0	0
25-05-05	Буталсан чулуун хольцыг дэвсгээр дэвсгэж суурь байгуулах	1м3	505	3.5 / 2873	0.21	104.55	300358	45354	0	345712
25-05-02	Замд тохиромжтой хөрс нэмж хучилт байгуулах б-200мм	1м3	505	3.0 / 2670	0.2	100.72	268921	40607	0	309528
					хүн/цаг:	224.87	626408	Нийт Цалин		720 995

УЛААН ТОЛГОЙ БАГИЙН 14,15 -Р ГУДАМЖНЫ ДУНД / 424М X 5М/

Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэрэг/Тариф	Нэгж хүн-цаг	Нийт хүн-цаг	Бүгд цалин	Нэмэгдэл цалин	Алслагтын нэмэгдэл	Нийт цалин
25-02-01	Замын чигийг сэргээх	1км	0.424	3.6 / 2914	38.82	16.46	47966	7243	0	55208
25-04-69	Тохиромжгүй материалыг ухаж ачих б-300мм	1м3	636	0.0 / 0	0	0	0	0	0	0
25-05-05	Буталсан чулуун хольцыг дэвсгээр дэвсгэж суурь байгуулах	1м3	424	3.5 / 2873	0.21	87.78	252182	38079	0	290261
25-05-02	Замд тохиромжтой хөрс нэмж хучилт байгуулах б-200мм	1м3	424	3.0 / 2670	0.2	84.56	225787	34094	0	259881
					хүн/цаг:	188.8	525934	Нийт Цалин		605 351
						413.67	1152328	Бүгд цалин:		1 326 329

НИЙТ БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ХЭРЭГЦЭЭ

Шифр	Материалын нэр	Х/Н	Нийт орц	Нэгж үнэ	Нийт үнэ
2-014	Ус	м3	93.92	2000	187 844
5-048	Тохиромжгүй материал	м3	1 393.5	0	0
6-017	Төмөр гадас d13мм x200мм	ш	48.31	1500	72 462
6-013	Төмөр гадас d13мм x500мм	ш	89.46	1500	134 194
6-012	Төмөр гадас d22мм x200мм	ш	4.83	1500	7 246
3-003	Бетон хольц м-150	м3	0.12	135000	15 911
9-093	Дүүргэлтийн чулуу	м3	952.22	2500	2 380 563
9-095	Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц	м3	952.22	2500	2 380 563
6-010	Модон гадас 5x5x40см (0.001м3)	ш	96.62	1500	144 924

5 323 706

НИЙТ БАРИЛГЫН МАШИН МЕХАНИЗМЫН ХЭРЭГЦЭЭ

Шифр	Машин механизмын нэр	Хучин чадал	Төрөл	Нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ
04*01	Усны машин	6тн	1	11.06	38820	429 159
01*01	Экспаватор	0.25м3	1	155.61	52458	8 162 858
02*01	Бульдозер	105м.х	1	7.26	51955	377 442
03*01	Автогрейдер	105м.х	1	9.4	30389	285 702
17*01	Ачигч	1.25м3	1	17.86	28281	504 968
05*03	Доргуурт хосолмол булт индүү	10-12тн	1	50.33	36137	1 818 892
08*	Дайрга тараагч	7м	1	16.23	38500	624 841
53*01	Пиқан	4хүн	1	43.77	6500	284 519
				311.52		12 488 380

НИЙТ БАРИЛГЫН ТЭЭВРИЙН ТООЦОО

Шифр	Материалын нэр	Х/Н	Цэвэр жин	Көэф	Зэрэг	Нийт орц	Зай	Тариф	Нийт жин	Нийт үнэ
9-093	Дүүргэлтийн чулуу	м3	1.7	1.03	2	952.22	3	691.21	1 667.35	3 457 459
6-017	Төмөр гадас d13мм х200мм	ш	0.012	1.04	1	48.31	32	289.41	0.6	5 583
6-013	Төмөр гадас d13мм х500мм	ш	0.0012	1.04	1	89.46	32	289.41	0.11	1 034
6-012	Төмөр гадас d22мм х200мм	ш	0.0011	1.04	1	4.83	32	289.41	0.01	51
6-010	Модон гадас 5х5х40см (0.001м3)	ш	0.00065	1.04	1	96.62	32	289.41	0.07	605
2-014	Ус	м3	1	1.011	2	93.92	1	1272.78	94.96	120 857
5-048	Тохиромжгүй материал	м3	1.4	1.01	1	1 393.5	2	612.3	1 970.41	2 412 963
3-003	Бетон хольц м-150	м3	2.4	1.015	2	0.12	5	583.93	0.29	838
9-095	Зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй элс хайрганы хольц	м3	1.7	1.01	1	952.22	3	508.85	1 634.97	2 495 864
8 495 254										